



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/97

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх 50 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ц. Буманбуян (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

С. Аюурзана (Төв аймгийн “Барилга захиалагч орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын инженер)

С. Эрдэнэчимэг (Иргэний төлөөлөл), (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Т. Гүрбазар (Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн дарга)

Нарийн бичгийн дарга:

А. Зоригоо (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)

2. 50 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Буманбуян)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Үнэлгээний хороо (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР

4122010291